

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.120

Таримал ногоон тэжээл. Техникийн шаардлага	MNS 6788:2019
Green fodder. Technical requirement	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн С/52 тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1. Зорилго

Таримал ногоон тэжээл бэлтгэх, нийлүүлэх, хүлээн авахад чанар байдлыг шалгахад тавигдах шаардлагыг тогтооно.

2. Хамрах хүрээ

Энэ стандарт нь зориулалтын техникээр боосон, хуйлсан таримал ногоон тэжээлийн чанар байдлыг тогтоох, зах зээлд нийлүүлэх, түүнийг хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих хүрээг хамарна.

3. Норматив эшлэл

Энэ стандарт нь дараах стандартуудыг эш татаж хэрэглэсэн ба стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас эш татан хэрэглэнэ. Үүнд:

- MNS 0592: 2008 Өвс: Техникийн шаардлага
- MNS 5647: 2006 Өвс, тэжээл тээвэрлэлт, Ангилал, Тээвэрлэлтийн нөхцөл
- ГОСТ 27978-88: Ногоон тэжээл. Техникийн шаардлага
- ГОСТ Р 55452-2013 Өвс, хадлан тэжээл. Техникийн шаардлага
- ГОСТ 23153-78. Тэжээлийн үйлдвэрлэл. Нэр томьёо тодорхойлолт

4. Нэр томьёо , тодорхойлолт

4.1. Таримал ногоон тэжээл

Нэг болон олон наст үет, буурцагт таримал ургамлуудыг хамгийн их шим тэжээлийн бодис хуримтлуулсан хөгжлийн үе шатанд /үет ургамалд түрүүлэлт-сүүн болц, буурцагт ургамалд цэцэглэлт-буурцаглалт, болц гүйцээгүй үр тариаг гол хатгалтаас сүүн болц/ хадаж бэлтгэн, хатааж боосон иш, түрүү болон буурцаг бүхий таримал ургамлаар бэлтгэсэн сайн чанарын тэжээл юм.

4.2. Боосон таримал ногоон тэжээл

Таримал ургамал, тэдгээрийн холимгийг хадаж хатаасны дараа хаман боогчоор дөрвөлжин хэлбэртэйгээр шахаж боосон тэжээл

4.3. Хуйлсан таримал ногоон тэжээл

Таримал ургамал, тэдгээрийн холимгийг хадаж хатаасны дараа зориулалтын хуйлагч ажиллагаа бүхий техникээр бөөрөнхий цилиндр хэлбэрээр бэлтгэсэн тэжээл

5. Ангилал

5.1. Таримал ногоон тэжээлийг таримлын төрлөөс хамааран доорх байдлаар ангилна.

1. Буурцагт ургамал давамгайлсан /буурцагт ургамал 50%-иас багагүй/
2. Буурцагт ба үет үр тарианы холимог /буурцагтны агуулалт 20%-иас багагүй/
3. Үет үр тариа давамгайлсан /үет таримал 50%-иас багагүй/
4. Болц гүйцээгүй үр тариа дагнасан

5.2. Бэлтгэсэн байдлаар нь:

- А. Боосон
- Б. Хуйлсан

6. Техникийн шаардлага

6.1. Таримал ногоон тэжээлийг хадах, тармах, хаман боох, хуйлах, нуруулдах, ачиж буулгах, тээвэрлэх, хадгалахдаа батлагдсан технологийн зааврыг баримтална.

6.2. А хавсралт-д заасан хортой болон хөнөөлт ургамлын нэр томъёог хавсаргав.

6.3. Нэг ба олон наст үет, буурцагт таримлаар бэлтгэсэн таримал ногоон тэжээлийн ургамлын бүрэлдэхүүн, физик, хими, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг 1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

1-р хүснэгт

Үзүүлэлт		Ногоон тэжээлийн төрөл			
		Буурцагт ургамал давамгайлсан	Буурцагт ба үет таримлын холимог	Үет таримал давамгайлсан	Болц оройтсон үр тариа дагнасан
Гадаад байдал	Өнгө	Шаргал ногоон /үет/, ногоон, ногоон хүрэндүү /буурцагт/			Шар ногоон
	Үнэр	Үр тариан өвсний анхилуун өвөрмөц үнэртэй. Ялзарсан, хөгцөрсөн үнэртэй байж болохгүй			
	Бусад хольц	Шороо, чулуу, шатах тослох материалаар бохирдоогүй			
	Хэлбэр	Боосон ба хуйлсан			
Агууламж	Уургийн агууламж, %-иас багагүй	13	9	6	4
	Эслэгийн агууламж, %-иас ихгүй	18	19	23	25
	Үнсний агууламж, %-иас багагүй	7	8	9	9
	Чийгийн агууламж, %-иас ихгүй	18			
Аюулгүй байдал	Ургамлын хольц. Жингийн хувь	Хорт болон хөнөөлт ургамал 1-ээс ихгүй			
	Пестицидийн үлдэгдэл	Байж болохгүй			
	Хүнд металын үлдэгдэл				

ТАЙЛБАР: Пестицид болон хүнд металын үлдэгдлийг маргаантай нөхцөлд тодорхойлно.

7. Ногоон тэжээлийн чанарыг үнэлэх

7.1. Ногоон тэжээлийн химийн найрлагыг тодорхойлох, шалгаж хүлээж авахдаа дараах стандартуудыг баримтална.

- MNS 4261:1995, Төрөл бүрийн тэжээлээс лабораторийн шинжилгээнд дээж авах арга
- MNS 6548:2015, Мал амьтаны тэжээл, бэлчээрийн ургамалд анхны чийг, хуурай бодис, үнс тодорхойлох жингийн арга
- MNS 6549:2015, Мал амьтаны тэжээл, бэлчээрийн ургамалд нийт уураг тодорхойлох арга
- MNS 6551:2015, Мал амьтаны тэжээл, бэлчээрийн ургамалд нийт эслэг тодорхойлох анкомын арга
- MNS 4833:1999, Хүнсний бүтээгдэхүүнд хлор органик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга
- MNS 4496:1997, Хүнсний бүтээгдэхүүнд хар тугалганы агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн аргаар тус тус тодорхойлно.

7.2. Ногоон тэжээлийн ургамлын бүрэлдэхүүнийг тодорхойлох

Ургамлын бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо боосон ба хуйлсан таримал ногоон тэжээл тарьсан талбайгаас хадахын өмнө 4-өөс доошгүй давталттай дээж авч үетэн, улалж, буурцагтан, алаг өвс, хортой ургамал гэх мэтээр ангилан ялгаж, төрөл тус бүрийг жинлэж, эзлэх хувийг (X) дараах томъёогоор бодож гаргана.

$$X = J \cdot 100 / J_1$$

X- нийт ногоон тэжээлд эзлэх хувь

J- тухайн төрлийн ургамлын жин, гр

J₁ - авсан дээжийн нийт жин, гр

8. Ногоон тэжээлийн нягтралыг тодорхойлох

8.1. Боосон болон хуйлсан ногоон тэжээлийн нягтралыг 50-иас 500 кг даацтай жин, 5 метрээс доошгүй урттай туузан метрийн тусламжтайгаар тодорхойлно. Боосон болон хуйлсан ногоон тэжээлийн нягтралыг дараах томъёогоор бодож олно.

а) $x = T / B_1 \cdot B_2 \cdot B_3$

x- боосон ногоон тэжээлийн нягт, кг/м³

B₁ – боосон ногоон тэжээлийн урт, м

B₂ – боосон ногоон тэжээлийн өргөн, м

B₃ – боосон ногоон тэжээлийн өндөр, м

T- боосон ногоон тэжээлийн жин, кг

б) $x = T / S \cdot B_1$; $S = \pi r^2$

x- хуйлсан ногоон тэжээлийн нягт, кг/м³

B₁ – хуйлсан ногоон тэжээлийн урт, м

T- хуйлсан ногоон тэжээлийн жин, кг

S- хуйлсан ногоон тэжээлийн тойргийн талбай м²

r- радиус, м π=3.14 тогтмол тоо

9. Таримал ногоон тэжээлийг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах

- 9.1. Стандартын шаардлага хангаж бэлтгэсэн таримал ногоон тэжээлийг баталгаажсан жин хэмжүүрээр жигнэж хүлээн авна.
- 9.2. Таримал ногоон тэжээлийг нийлүүлэхдээ гарал үүслийн тодорхойлолт, стандартад тэнцсэн шинжилгээний дүнг дагуулан хүргүүлнэ.
- 9.3. Таримал ногоон тэжээлийг MNS 5647:2006 -ийн дагуу тээвэрлэнэ.
- 9.4. Ногоон тэжээлийг хуурай сэрүүн нөхцөлд саравч, ус шорооноос хамгаалсан хучлага дор хананаас 1 м, шалнаас 20 см зайтай мөн нуруулдан хурааж, 20 сар хүртэл хугацаагаар хадгалж болно.

ТӨГСӨВ.

А. ХАВСРАЛТ

Таримал тэжээлд орж болохгүй хортой болон хөнөөлт ургамлын жагсаалт

Монгол нэр	Латинское названия растения	Русское название растения
Хар лантанз	Hyoscyamus niger.L	Белена чёрная
Хорс	Anonitum L.	Борец /аконит/
Хахуун голын хор	Cicuta virosa L.	Вех ядовитый
Мөлхөө Ягаан толгой	Acroptilon repens L.	Горчак ползучий
Хорт хамбий	Sisymbrium toxophyllum C.A.M.	Гулявник ядовитый
Үетэнэрхүү ажигана	Stellaria graminea L.	Звездчатка злаковая
Намгийн бальви	Caltha palustris L.	Калужница болотная
Зохимон	Senecio L.	Крестовник
Холтсон цэцэг	Ranunculus L.	Лютики
Хонин зажлуур /мөлхөө/	Linaria vulgaris Mill.	Лынянка обыкновенная
Намуу	Papaver rhoeas L.	Мак-самосейка
Сүүт өвс	Euphorbia esula L.	Молочай острый
Элбэг тайжийн жинс	Echinops ritro.L	Мордовник степной
Эгэл бавран	Pteridium aquilinum L.	Орляк обыкновенный
Дошинцог	Galeopsis L.	Пикульник
Лолиум	Lolium temulentum L.	Плевел опьянящий
Европ ороонго	Cuscuta europaea L.	Повилика европейская
Намгийн шивлээ	Equisetum palustre L.	Хвоц болотный
Хөдөөгийн шивлээ	Equisetum arvense L.	Хвоц полевой
Голын шивлээ	Equisetum fluviatile L.	Хвоц топяной
Цагаан агширгана	Veratrum lobelianum Bemh.	Чемерица Лобеля
Нэг наст Аргуй	Stachys annua L.	Чистец однолетний
Эгц Аргуй	Stachys recta L.	Чистец прямой
Их шүүдэргэнэ	Chelidonium majus L.	Чистотел большой

Тайлбар: Ишлэл авсан хэвлэл:

МОНГОЛ ОРНЫ ГУУРСТ ДЭЭД УРГАМЛЫН ХУРААНГУЙ ЖАГСААЛТ

